

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН  
ХОРООНЫ 2017 ОНЫ АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2018.02.22

*Иргэний хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбоотой өргөн асуудлуудыг шийдвэрлэхэд санал оруулах, хөдөлмөрлөх явцад ажлын орчин нөхцлийг дээшлүүлэх, нийгмийн асуудлаа (цалин хөлс нэмэгдүүлэх, тэтгэмж дэмжлэг үзүүлэх бусад) шийдвэрлэхэд нь ажил олгогч болон холбогдох газруудад уламжлах, шийдвэрлүүлэхэд гол зорилтоо болгосон иргэдийн дуу хоолойг бодлого боловсруулагчид, ажил олгогчид хүргэж байдаг ажилдын эрх ашгийг хамгаалсан төрийн бус байгууллага бол Үйлдвэрчний эвлэлийн хороод байдаг.*

*Энэ ч утгаараа байгууллагуудын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоодууд нэгдэж иргэн та бүхний эрхийг хамгаалан цалин хөлс нэмэгдүүлэх, хуулиудад нэмэлт өөрчлөлтийг оруулах, нийгмийн асуудлаа шийдвэрлүүлэх талаар тэмцэж үр дүнд хүрч байсан нь олонтой.*

*Аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрчний эвлэлийн хороо нь Засаг даргын Тамгын газрын нийт ажилчдын хуралдаанаар байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хорооны тэргүүлэгч, даргаа сонгож үйл ажиллагаагаа шинэ бүрэлдэхүүнтэйгээр эхлүүлснээс хойш 3 жил гаруйн хугацаа өнгөрч, хамтын гэрээг шинээр байгуулан баталгаажуулж ажиллаж байна.*

*Энэ хугацаанд аймгийн Засаг даргын Үйлдвэрчний эвлэлийн хороо нь нийт ажилчдынхаа сэтгэлд нийцсэн арга хэмжээг зохион байгуулах, хамт олон болон байгууллагаас зохион байгуулагдаж буй ажил, үйл ажиллагаанд Үйлдвэрчнийхээ эвлэлийн гишүүдийн нэрийн өмнөөс тодорхой санхүүжилт үзүүлж хамтарч ажиллах, тэдний санал, сэтгэгдлийн мөрөөр тодорхой ажлуудыг хийж, холбогдох удирдлагуудад танилцуулж ажилтан, албан хаагчдынхаа эрх ашгийг нь хамгаалах, зохион байгуулж буй ажил, санхүүгийн орлого, зарлагаа Засаг даргын Тамгын газрын веб хуудсанд тогтмол байршуулах, хагас жилээр байгууллагын ажилчдад нэг удаа тайлангаа танилцуулах зэргээр хамт олондоо ил тод нээлттэйгээр ажиллахад илүүтэй анхаарч ажиллаж ирлээ.*

*Тус онд байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос төрийн албан хаагчдын тэтгэвэрийн насыг нэмэгдүүлэхгүй байх, төрийн албан хаагчдын цалинг урамшуулал, нэмэгдэл маягаар ялгавартайгаар ажлын үр дүнтэй уялдуулан олгох, иргэдийн татварыг нэмэхгүй байх, багш, эмч*

мэргэжилтнүүдийг 25 жил ажилласан тохиолдолд өөрийн хүсэлтээр тэтгэвэрт гарах боломжийг хуульд нэмэлтээр оруулах, төрийн албан хаагчдын халаа солиог ажлын туршлага, дадлага, мэргэжлийг харгалзан өөрчлөх, соёлын салбарын ажилчдын цалин, тэтгэмжийн олгох талаар хуулинд заалт оруулах зэрэг нийгмийн шинжтэй асуудлуудыг салбарын байгууллагадаа хүргүүлэн үйл ажиллагааг нь дэмжиж ажиллаа.

2017 онд аймгийн Засаг даргын Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн орлого бүрдүүлсэн байдал:

**Хүснэгт 1. 2017 оны гишүүдийн татварын орлогын дүн**

| Он сар өдөр   | Орлогын нэр   | Орлогын хэмжээ (мян төг) |
|---|---|--------------------------|
| <b>2016 оны жилийн эцсийн үлдэгдэл</b>  |   | <b>2222.417.00</b>       |
| 2017.01.26  | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар       | 353.131.00               |
| <b>2017.02.15</b>   | <b>НҮА-ны гишүүдийн татвар</b>                            | <b>340.490.00</b>        |
| 2017.03.28  | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар       | 364.794.00               |
| 2017.03.28  | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар       | 374.643.00               |
| 2017.04.25  | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар       | 377.841.00               |
| 2017.05.25  | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар       | 393.274.00               |
| <b>2017.05.30</b>   | <b>НҮА-ны гишүүдийн татвар</b>                            | <b>335.510.00</b>        |
| 2017.06.30  | <b>НҮА-ны гишүүдийн татвар</b>                            | <b>317.753.00</b>        |
| 2017.07.21  | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар       | 796.851.00               |
| 2017.09.27  | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн сарын татвар | 44.810.00                |
| 2017.09.27  | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн сарын татвар | 813.796.00               |
| 2017.10.27  | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар       | 368.498.00               |
| 2017.10.30  | <b>НҮА-ны гишүүдийн татвар</b>                            | 714.000.00               |
| 2017.11.22  | <b>НҮА-ны гишүүдийн татвар</b>                            | 177.498,00               |
| 2017.11.27  | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар       | 387.625.00               |
| 2017.12.19  | <b>НҮА-ны гишүүдийн татвар</b>                            | 212.386.00               |
| 2017.12.22  | Тамгын газрын үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн татвар       | 423.803.00               |
| <b>2017 ОНЫ ОРЛОГЫН ДҮН: 6796.703.00 (Зургаан сая долоон зуун ерэн зургаан мянга долоон зуун гурван төгрөг)</b> |   |                          |
| <b>2016 оны үлдэгдэл ДҮН: 2222.417.00 (Хоёр сая хоёр зуун хорин хоёр мянга дөрвөн зуун арван долоон төгрөг)</b> |   |                          |
| <b>НИЙТ ОРЛОГЫН ДҮН: 9019.120.00 (Есөн сая арван есөн мянга нэг зуун хорин төгрөг)</b>                          |   |                          |

Дээрхи орлогыг зарцуулахдаа байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хорооны тэргүүлэгч гишүүдийн саналыг ямагт тусган ажилласан болно.

2017 оны аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрчний эвлэлийн холбооны гишүүдийн татварын орлогын зарцуулалтыг дэлгэрэнгүйгээр танилцуулахад:

**Хүснэгт 2. 2017 оны гишүүдийн татварын зарцуулалтын дүн:**

| Он сар өдөр   | Татварын зарлага / мян төг/ | Зориулалт   |
|---|-----------------------------|---|
| 2017.01.30  | 168.000.00                  | Хувцасны үнэ /сагсан бөмбөг/  |
| 2017.03.10  | 1152.000.00                 | Мартын болон цэргийн баярт зориулсан хэлтсүүдийн хоорондох нөхөрсөг тэмцээн   |
| 2017.03.10  | 714.000.00                  | Тамгын газрын ажилчдын спортын иж бүрэн ээлжийн хувцас  |
| 2017.03.10  | 93.500.00                   | Аймгийн МҮЭХ-ны төлөөлөгчийн 1 хүний буудлын зардал /Ном бүтээх/  |
| 2017.05.19  | 300.000.00                  |   |
| 2017.06.05  | 1000.000.00                 | Тамгын газрын ажилчдын хүүхдийн бэлэг   |
| 2017.06.07  | 30.000.00                   | Тэмцээний бооцооны үнэ /Энхмандал/  |
| 2017.06.16  | 98.000.00                   | Аймгийн ҮЭХ-ноос холбоо, хороонд 91 жилийн ой угтаж хуваарилан хийлгэсэн ажил /Аймгийн ҮЭХ-ны өмнөх самбарын аннонс шинэчилсэн/ |
| 2017.06.16  | 500.000.00                  | Үйлдвэрчний эвлэлийн хорооны 30 хувийн татварт  |
| 2017. 06.19   | 160.000.00                  | Монголын ҮЭХ-ны 100 жилийн ойн хандив   |
| 2017.07.27  | 70.200.00                   | П.Цэцэгсүрэнд тэмдэгтийн хураамжийн дэмжлэг   |
| 2017.09.14  | 2032.500.00                 | Байгууллагын ажилчдын Нэвтийн рашаан сувилалд амрах зардал  |
| 2017.10.27  | 132.000.00                  | Монголын ҮЭХ-ны 100 жилийн ойд оролцох замын зардал /автобусаар/  |
| 2017. 12.28   | 802.379.00                  | Байгууллагын ажилчдын хүүхдийн шинэ жилийн бэлэг  |
| 2017. 12.27   | 450.000.00                  | Байгууллагын үйлдвэрчний эвлэлийн тэргүүний гишүүдийн урамшуулал /Шинэ жилийн арга хэмжээний үеэр/                              |
| 2017.12.28  | 1328.000.00                 | Байгууллагын шинэ жилийн арга хэмжээний зардал  |
| 2017.12.28  | 700.000.00                  | Үйлдвэрчний эвлэлийн хорооны 30 хувийн татварт  |
| <b>ДҮН</b>  | <b>9016.579.00</b>          |   |
| <b>2017 ОНЫ НИЙТ ЗАРЛАГА: 9016.579.00 (Есөн сая арван зургаан мянга таван зуун далан есөн мянган төгрөг )</b> |                             |   |
| <b>НИЙТ ОРЛОГО /2016-2017/: 9019.120.00 (Есөн сая арван есөн мянга нэг зуун хорин төгрөг)</b>                 |                             |   |
| <b>2017 ОНЫ ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ 2.541.00 /Хоёр мянга таван зуун дөчин нэгэн мянган төг/</b>                       |                             |   |

2017 онд гишүүдийн татварын орлогыг үр дүнтэй зүй зохистой зарцуулахад анхаарч ажилласан ба өмнөх оны үлдээгдэл 2222.417.00 (**Хоёр сая хоёр зуун хорин хоёр мянга дөрвөн зуун арван долоон төгрөг**)-ийг нэмж тооцон зарлагыг хассанаар 2017 оны жилийн эцсийн байдлаар 2.541.00 төгрөг /**Хоёр мянга таван зуун дөчин нэгэн мянган** /-ийн үлдээгдэлтэй байна.

Энэ нь гишүүдийн татварын орлого өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.5 сая төгрөгөөр буурч орсон, татварын орлогоос хуримтлалын санд 1000 000 төгрөг зээлж эргэн төлөгдөөгүй зэрэг хүчин зүйл нөлөөлсөн байна.

Байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хороо нь гишүүдийг идэвхижүүлэх, хамтын үйл ажиллагааг бүх талаар дэмжих, тэмдэглэлт өдрүүд болон уралдаан тэмцээнд оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэх, хамт олны эвсэг хамтач үйл ажиллагааг дэмжиж ажиллав.

Мөн байгууллагын ажилчдын нийгмийн баталгааг хангах, өмнө батлагдсан дотоод журмын хэрэгжилт хангалтгүй, зарим заалт тухайлбал ажлын цагийн бүртгэлийг баримтлан цалин үндэслэлгүйгээр хасч олгож байгаа талаар ажилчдын мэдүүлсэн саналыг үндэслэж байгууллагын дотоод журмыг өөрчлөх талаар санал хүргүүлж, Нийгмийн бодлогын хэлтэс хариуцан хэлтэс болон ажилчдаас саналыг авч нэгтгэн шинэчлэн боловсруулж бүх нийтийн хурлаараа хэлэлцүүлэн шинэчилж батлууллаа.

Байгууллагын зарим ажилчдын ажлын байр өөрчлөх, чөлөөлөх, сахилгын арга хэмжээг авахад ажилчдыг төлөөлж биеэр уулзах болон албан тоотгоор асуудлаа танилцуулж зөв талаас нь шийдвэрлүүлэх зэргээр хамтарч ажиллав.

Тус онд Монголын үйлдвэрчний холбооны 100 жилийн ой, аймгийн Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны 91 жилийн ойг тохиолдуулан шилжин аялах тугаар байгууллагын үйлдвэрчний хорооны ажлаа сурталчлан танилцуулж, ойд 160 мянган төгрөгийн хандив өргөж, тус байгууллагад даргаар ажиллаж байсан үе үеийн үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга нарын материалыг бэлтгэн 100 жилийн ойн номонд оруулж хэвлүүлэн аймгийн Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны үүдний самбар, аннонсыг шинэчлэн дэмжлэг үзүүллээ.

2017 онд байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос зохион байгуулсан арга хэмжээг хувилж үзэхэд 2017 оны гишүүдийн татварын орлогын 3.9 сая буюу 58.6 хувийг байгууллагын хамт олны нийтээр зохион байгуулсан

*тэмдэглэлт арга хэмжээнд 2.3 сая буюу 34.2 хувийг байгууллагын ажилчдын хүүхдүүдэд хүүхдийн болон шинэ жилийн баяраар бэлэг өгөхөд, 0.8 сая буюу 12.9 байгууллагын спортын уралдаан тэмцээн, хувцас хэрэглэл авч өгөхөд зарцуулснаас гадна ҮЭХ-нд төлөх татвараа бүрэн төлж ажиллаа.*

*Мөн байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороо нь жил бүр тогтмол зохион байгуулдаг хэлтэс хоорондын уралдаан, тэмцээн, Эрүүл мэндийн үзлэг, нийтээр амрах, нийтийн биеийн тамирын арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.*

*Байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос уламжлал болгон зохион байгуулдаг Монгол цэргийн баяр, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хэлтэс хоорондын дунд спортын 6 төрлөөр 8 багийн нөхөрсөг тэмцээнийг зохион байгуулж, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн баг тэргүүлж байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хорооны шилжин явах цом гардлаа.*

*Мөн байгууллагын ажилчын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хэлтэс бүрээс саналыг авч нэгтгэн 42 хүнийг үзлэгт хамруулж эмчийн зөвлөгөө, зааварыг өгүүлж, шаардлагатай 4 хүнийг дараагийн шатлалын оношилгоонд хамрууллаа.*

*2017 оны 9 сард байгууллагын нийт ажилтныг Нэвт рашаан сувилалын амралтанд амраахад санхүүгийн дэмжлэг үзүүлж ажил олгогчтой хамтран ажилласнаас гадна байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хороонд ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу шаардлагатай дэмжлэгүүдийг үзүүлж, ажилласныг орлогын зарцуулалтын тооцоонд тусгасан болно.*

*Цаашид аймгийн Засаг даргын Тамгын газрын Үйлдвэрчний эвлэлийн хороо нь үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн үүрэг, тэдний бүтээлч ажлыг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, уламжлалт арга хэмжээгээ өндөр хэмжээнд зохион байгуулах, гишүүдийнхээ ирүүлсэн санал, өргөдлийг шуурхай шийдвэрлэхэд ажлаа чиглүүлэн хууль эрх зүйн талаар мэдээллийг авах хүсэлтийг үндэслэн сургалт мэдээллээр хангах, хамтын гэрээг шинэчлэн боловсруулж батлуулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.*

**ЗДТГ-ЫН ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН  
ХОРООНЫ ДАРГА**

**С.ДОРЖ**